



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

MONGOLIAN NATIONAL ARCHERY
FEDERATION
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХАРВААЧДЫН
ХОЛБОО

Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн
өргөн чөлөө, OLYMPIC HOUSE, 113 тоот
Утас: 8865-6513

И-мэйл: info@national-archery.mn

Огноо 2024.01.19 № 01/02

Танай _____ № _____ -т

С. Дорнод
Саяхуу, 11 тоо
Угсвэг
81 тоо
[Signature]
22/1

Хамтран ажиллах тухай

Дорнод аймгийн “Дорнын сурын холбоо” ГҮТББ-аас ирүүлсэн 2023.10.10-ны №06 тоот албан бичиг мөн холбооноос ирүүлсэн 2024.01.09-ний №01 тоот албан бичгийг үндэслэн Дорнод аймгийн Баян-Уул сумын уугуул Үндэсний их сурын ууган хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Гавьяат тамирчин, дархан мэргэн Аюушийн Цэвээн агсны мэндэлсний 100 жилийн ойн нэрэмжит болгон Үндэсний их сурын Улсын Аварга Шалгаруулах Тэмцээнийг Дорнод аймгийн Чойбалсан хотод 2024.06.22.23-нд зохион байгуулахаар МҮХХ-ны 2024 оны жилийн хуваарьт оруулан ажиллаж байна. Тиймээс тухайн хугацаанд УАШТ-ийг зохион байгуулахад аймаг орон нутгаас дэмжин ажиллахыг хүсье!

ХҮНДЭТГЭСЭН:

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХДАЛАЙ


Г. Төлөөгүрэн,
Э. Чинзориг дарга



Тэмцээний зохион
байгуулахад шаардлагатай
туслах, төлөвлөгөө
үрэгжилт танилцуулга
нальцсон шийдвэрийг
гарцуулах

[Signature]
22/1





“ДОРНЫН СУРЫН ХОЛБОО” ГҮТББ

Дорнод аймаг Чойбалсан хот,

Ардчиллын гудамж, Утас: 8955-1819

2024 оны 01 дүгээр сарын 09

№ 01

Хэрлэн сум

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХАРВААЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.МӨНХДАЛАЙ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Эрхэм таны амгаланг айлтгая.

Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахтай холбогдуулан дараахь мэдээллийг хүргүүлж байна.

1. Дорнод аймгийн Чойбалсан хот нь Зүүн бүсийн хөгжлийн тулгуур төв бөгөөд томоохон 6, жижгэвтэр мөн тооны буудлуудтай бөгөөд 1000 хүртэл харваачийг хүлээн авах бүрэн боломжтой.

2. Аймгийн 2024 оны төсөвт Үндэсний сурын цуваа харвааны Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах зардалд 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр тусгаж, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/57 дугаар захирамжийн хавсралтаар баталгаажуулж, албажуулсан.

Үндэсний сурын харвааны Улсын аварга шалгаруулах тэмцээний нийт төсөв урьдчилсан тооцооллоор 51,9 сая төгрөг болж байгаа бөгөөд аймгийн төсвөөс 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр батлагдсан бөгөөд бусад 31,9 сая төгрөгийг дараахь эх үүсвэрүүдээс бүрдүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр нь: Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавъяат тамирчин, Үндэсний сурын Дархан мэргэн Аюушийн Цэвээн агсны төрөлх нутаг Баян-Уул сум, мөн аймаг, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын ивээн тэтгэлэг, хандивын орлогоос бүрдүүлнэ.


3. Дорнод аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө болон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны уралдаан, тэмцээний хуваарьт тусгуулж батлуулсан саналын дагуу 2024 оны 06 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд Чойбалсан хотод зохион байгуулах саналыг Монголын Үндэсний Харваачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн даргад уламжилж байна.

Орон нутгийн төсвийн төсөлд тусгуулсан саналыг Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны 11-р сарын 29-нд Төрийн аудитын байгууллагад хянуулахаар хүргүүлэхдээ удирдамжийн төсөл, төсвийн саналаа гаргаж хүргүүлсэн. Аудитын байгууллагын хянаж, зөвшөөрснөөр батлагдсан төсөв, хуваарийн дагуу Монголын Үндэсний Харваачдын холбоонд 2024 оны хуваарьт тусган батлуулахаар хүргүүлэв.

Хүлээн авч шийдвэрлэж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Тэмцээний урьдчилсан төсвийн тооцооллыг файлаар хавсаргав.

Хүндэтгэсэн,





“ДОРНЫН СУРЫН ХОЛБОО” ГҮТББ

Дорнод аймаг Чойбалсан хот,

Ардчиллын гудамж, Утас: 8955-1819

2023 оны 10 дугаар сарын 10

№ 06

Хэрлэн сум

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХАРВААЧДЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Э.МӨНХДАЛАЙ ТАНАА

Хамтран ажиллах тухай

“Дорнын сурын холбоо”-ноос санаачлан Дорнод аймгийн Баян-Уул сум үүсч байгуулагдсны түүхт 100 жилийн ойн хүрээнд тус сумын уугуул, Үндэсний их сурын ууган Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Гавъяат тамирчин; Дархан мэргэн Аюушийн Цэвээн агсны мэндэлсний 100 жилийн ойн нэрэмжит Үндэсний сурын улсын аварга шалгаруулах үндэсний сурын цуваа харвааны тэмцээнийг зохион байгуулах талаарх заалтыг “Дорнод аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгуулан батлуулаад байна.

Энэхүү тэмцээнийг 2024 оны 06 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд Та бүхэн Монголын Үндэсний Харваачдын холбооны ирэх жилийн уралдаан, тэмцээний төлөвлөгөө, графикт тусган хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн,

